Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Засаг даргын тамгын газар нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын 2020 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/09 тоот тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөж байна.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны А/299 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар "Хөтөлбөр батлах тухай" тушаалаар аккрузал суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8,782.5 сая төгрөгөөр буюу 185.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	6,400.7	572.8	-5,827.9
Авлага	-	7,928.2	-7,928.2
Бараа материал	45,431.3	48,816.4	3,385.1
Үндсэн хөрөнгө	11,813,393.4	12,702,845.6	889,452.1
Нийт хөрөнгө	11,865,225.3	12,760,162.9	894,937.6
Өр төлбөр	=	=	
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	11,865,225.3	12,760,162.9	894,937.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	11,865,225.3	12,760,162.9	894,937.6

Дээрх хүснэгтээс харахад мөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр дансанд өөрчлөлт гарсан байна.

Жилийн эцэст 0.6 сая төгрөгийн Ахмадын сангийн дансны үлдэгдэлтэй гарсан байна.

Бараа материалын данс 48.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарч оны эхнээс 3.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр нийт 345.4 сая төгрөгийн бараа материал худалдан авч 342.6 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс оны эхэнд 11,813.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд төсвийн хөрөнгөөр 40.1 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч, 1,095.9 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Засгийн газрын хувь оролцоо данс тайлант оны үр дүнтэй холбоотой 894.9 сая төгрөгөөр өссөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Аймгийн Засаг даргын тамгын газар нь 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,916.3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, нийт зарлагыг 3,916.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Аймгийн Засаг даргын тамгын газрын тайлант оны төсвийг анх 6,610.7 сая төгрөгөөр баталж, төсвийн тодотголоор 483.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 7,093.7 сая төгрөгөөр тодотгож баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 6,371.4 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1.0 сая төгрөг оруулан нийтдээ 6,369.1 сая төгрөгийн зарлага санхүүжилтээр үйл ажиллагаа явуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 6,369.1 сая төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 2.3 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	4,701,312.4	4,672,135.0	-29,177.4	99
2	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж	351,121.9	351,120.9	-1.0	100
3	81102-Орон нутгийн нөөц хөрөнгө	1,230,000.0	1,042,299.9	187,700.1	85
4	81104-Бусад ангилагдаагүй нөөц хөрөн	642,500.0	248,520.9	-393,979.1	39
5	81404-Дамжуулан зээлдүүлсэн зээл	113,602.5	0.00	-113,602.5	0
6	81519-Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх	3,200.0	3,198.2	-1.8	100
7	82801-Улсын баяр наадам	52,000.0	51,819.3	-180.7	100
	Дүн	7,093,736.8	6,369,094.2	-724,642.6	90

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Санхүү-нийцлийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлийн судалгааны дүн дараах байдалтай байна. Үүнд:

Ахмадын сангийн харилцах данс, оны эхэнд 6.4 сая төгрөгийн эхний үлдэгдлээс ахмад настнуудад 5.8 сая төгрөгийг зарцуулж жилийн эцэст 0.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гаргаж ажиллаагүй байна.

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн 210801 дансанд төсөв тусгагдаагүй ба бараа үйлчилгээний бусад зардлын 210901 дансаар 1,207.2 сая төгрөгийг зарцуулсан ба алдаа, зөрчил ирээгүй.

Байгууллагын 2024 оны орон тооны судалгааг гаргуулж авч, хянаж үзэхэд батлагдсан орон тооны хязгаарыг баримталж ажилласан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар архивын Ерөнхий газраас 54.7 сая төгрөг, Эрчим Хүчний яамнаас Эрдэнэбүрэн усан цахилгаан станцын нөхөн олговорт 7,891.1 сая төгрөг, Төрийн албаны салбар зөвлөлийн шалгалтын зардалд 6.4 сая төгрөг, Архивын тасгийн лавлагааны хураамжийн орлого 3.9 сая төгрөг, “UNITED NATIONS CHILDRENS FUND” Дэлхийн хүүхдийн сангаас 93.7 сая төгрөг, Мобиком корпораци ХХК-аас мобиком сайтын түрээсний орлогоос 3.0 сая төгрөг, Хөдөлмөр халамж, үйлчилгээний газраас түрээсний орлого 0.02 сая төгрөг, Засгийн газрын хэрэг эрхлэг газраас 27.9 сая төгрөг нэмэлт санхүүжилт хүлээн авчээ.

Үүнээс дансны хуулгаар авч үзэхэд цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 54.7 сая төгрөг, Түлш Эрчим Хүчний яамнаас олгосон Эрдэнэбүрэн усан цахилгаан станц нөхөн олговорт 7,860.9 сая төгрөг, аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт 69.2 сая төгрөг, аймгийн Эрүүл мэндийн газарт 24.5 сая төгрөг, Шинэ хоршоо хөдөлгөөн нээлтийн арга хэмжээнд оролцсон замын зардалд 27.9 сая төгрөг, Төрийн албаны салбар зөвлөлийн өвлөлийн ажлын хэсгийн урамшуулал, үйл ажиллагааны зардалд 6.4 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 6.8 сая төгрөгийг зарцуулж, 30.3 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Аймгийн Засаг даргын тамгын газарт 2024 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу аймгийн Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Нурлан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн №З-3-02/61 тоот дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг Баян-Өлгий аймгийн Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 10,992.5 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 164.9 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд Аймгийн Засаг даргын тамгын газар нь нийтдээ 24.1 сая төгрөгийн төгрөгийн багаж, техник хэрэгсэл шууд гэрээгээр худалдан авч төрийн цахим худалдан авалтыг хэрэгжүүлээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг шилэн дансны мэдээллийг 869,400.0 мянган төгрөгийн мэдээлэх ёстойгоос 747,793.2 мянган төгрөгийн мэдээлж нийтдээ 121,606.8 мянган төгрөгийг шилэн дансанд дутуу мэдээлсэн байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 11,823,550.0 мянган төгрөгийг мөнгөн гүйлгээг шилэн дансанд мэдээлсэн боловч тус цэсэд орлогыг мэдээлэх ёстойгоос цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээг байршуулж алдаатай мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Аймгийн Засаг даргын тамгын газрын 2024 онд эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 540.9 сая төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	1	540.9	1	540.9	100
Нийт дүн	1	540.9	1	540.9	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалж эрсдэлтэй гэж сонгосон данс, ажил гүйлгээнүүдэд горим сорил хэрэгжүүлсэн ба төсвийн зарцуулалтыг гүйцэтгэлийн шалгалтаар дэлгэрэнгүй шалгах шаардлагатай. Санхүүгийн тайланг хуулийн хугацаанд, аудитад шаардлагатай нотлох баримтын хамт ирүүлж хэвших.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй. Аудитаар нийтдээ 12,118.1 сая төгрөгийн зөрчил илэрч 19.6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 109.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 11,988.7 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөгдлөө.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар 19.6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоов.

1.Аймгийн Засаг даргын тамгын газар нь 2024 онд хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдад 5 жил тутам нэг удаа олгох мөнгөн урамшууллын тооцоогоор аймгийн Засаг даргын 2024 оны 04-р сарын 09-ний өдрийн Б/12 дугаар захирамжаар 3, Засаг даргын тамгын газрын даргын 2024 оны 04-р сарын 12-ны өдрийн Б/20 дугаар тушаалаар 22 нийтдээ 25 албан хаагчид 195.8 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олгохдоо 19.6 сая төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутгаагүй олгосон байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Татварын хууль тогтоомжид хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно”, 6.1.19-д “суутган төлөгч” гэж тухайн төрлийн татварын хуулийн дагуу татвар төлөгчийн төлөх татварыг суутгаж, төсөвт шилжүүлэх, тайлагнах үүрэг бүхий этгээдийг”, 28 дугаар зүйлийн 28.7-д “Суутган төлөгч нь татварын хууль тогтоомжийн дагуу тухайн төрлийн татвар төлөх үүрэг бүхий этгээдээс албан татварыг ногдуулан суутгана.”,

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д “Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно”, 6.3.1-д “цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого”, 21-р зүйлийн 21.1-д “Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тухайн жилийн орлогыг тодорхойлоход 0-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 10 хувиар,..... тооцон албан татвар ногдуулна”, 25 дугаар зүйлийн 25.1-д “Энэ хуулийн 4.1.11-д заасан суутган төлөгч албан татвар ногдуулахад доор дурдсан журмыг баримтална”, 25.1.1-д “энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Мөнгөн урамшууллын дүнгээс 19.6 сая төгрөгийн татварыг нөхөн төлүүлэх акт тогтоов.

5.2 Албан шаардлага.

Аудитаар 109,846.0 мянган төгрөгийн албан шаардлага өгсөн..

1.Аймгийн засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 25-ний өдрийн А/812 тоот захирамжаар 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг үнэн зөв, алдаа, зөрчилгүй тайлагнасан хавсралтад заасан албан хаагч нийтдээ 8.5 сая төгрөгийн урамшуулал, 2.Аймгийн Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ний өдрийн Мөнгөн шагнал олгох тухай 106 тоот тушаалын хавсралтад заасан нэр бүхий 16 албан хаагч нарт үндсэн цалингийн 30-50 хувиар бодож 10.5 сая төгрөгийн, 2024 оны 12 дугаар сарын 18-ний өдрийн Мөнгөн шагнал олгох тухай 105 тоот тушаалын хавсралтад заасан нэр бүхий 28 албан хаагч нарт үндсэн цалингийн 30-40 хувиар бодож 12.5 сая төгрөгийн нийтдээ 22.9 сая төгрөгийн мөнгөн шагнал олгож, төсвийг үр ашиггүй зарцуулсан.

3.Тус тамгын газрын нэр бүхий 57 албан хаагчид албан томилолтоор ажилласан нийт 813 хоногийн албан томилолтын мөнгийг тооцож олгохдоо ажлын 637 хоногт ногдох 8.6 сая төгрөгийн хоолны хөнгөлөлтийг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5-д “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсгийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Засгийн газрын 2019 оны “Журам батлах тухай” 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2-т “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна”, Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолын хавсралтын 8.4 дэх хэсэг, Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн “Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай” 120 дугаар тушаал, 2024 оны 04-р сарын 01-ны өдрийн “Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай” А/52 дугаар тушаалыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:Төрийн албан хаагчид олгох мөнгөн урамшууллыг холбогдох хууль, журам зөрчиж тогтоосон хэмжээнээс хэтрүүлэхгүй байх, албан хаагчдад ажлын өдөр томилолтоор ажилласан хугацаандаа хоолны мөнгийг давхардуулан олгохгүй байх;

2. Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 2024 онд 18 төрлийн арга хэмжээнд зарцуулсан 69.8 сая төгрөгийн зардлын тайланг уг хөрөнгийг хариуцаж тайлагнах байгууллагуудаас гаргуулан авч хянаж, баримтжуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 6 дугаар зүйлийн 6.1-д “Нөөц хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээг хариуцан гүйцэтгэж байгаа байгууллага, ажилтан хөрөнгийн зарцуулалтын тайланг уг арга хэмжээг хэрэгжүүлж дууссанаас хойш ажлын 15 хоногийн дотор гаргаж, тухайн шатны Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ”, 6.2-т “Нөөц хөрөнгийн зарцуулалтын тайланг санхүүжүүлсэн зардал, арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө, төсөвтэй зэрэгцүүлэн гаргаж, байгууллагын дарга, нягтлан бодогч нар гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулан холбогдох баримтыг хавсаргана”,

Сангийн Сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан “ Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийлэг хэрэглэгдэх анхан шатны баримтыг нөхөх нийтлэг заавар”-ын 6 дугаар зүйлийн 5 дахь заалтыг гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Засаг даргын нөөц хөрөнгөнөөс зарцуулсан хөрөнгийн зарцуулалтын тайланг хариуцсан байгууллагуудаас гаргуулан авч, баримтжуулан Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтын нийтлэг журмыг хэрэгжүүлж ажиллах.

Зөвлөмж

Аудитаар 11,988.7 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөгдлөө.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хөрөнгийн бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Аймгийн Засаг даргын 2024 оны 06-р сарын 04-р сарын А/438 дугаар захирамжаар Засаг даргын нөөц хөрөнгийн төсвөөс сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой худалдан авсан 36.0 сая төгрөгийн хяналтын камерыг үндсэн хөрөнгийн дансанд орлогод аваагүй, данс бүртгэлд тусгаагүй орхигдуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 4.4.2 "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэсэн заалтыг зөрчсөн:

1.2. Өгсөн зөвлөмж:

Засаг даргын нөөц хөрөнгийн төсвөөр худалдан авсан хяналтын камерыг үндсэн хөрөнгө дансанд орлогод авч, данс бүртгэлд тусгаж зөрчлийг арилгах.

2. Өр төлбөрийн бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

"Нээлттэй Баян-Өлгий 2023 эдийн засгийн форум чуулга уулзалт"-ын 2023 онд зохион явуулсантай холбоотой гарсан зардлыг 2023 оны санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй боловч Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 2024 оны 1-р сард 7.6 сая төгрөгийг шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.3-т "бүх өр төлбөр" гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Тооцоогоор үүсэн өр төлбөрийг санхүүгийн тайланд өглөгөөр бүрэн тусган тайлагнах, тооцоо нийлж баталгаажуулаагүй өглөгийг шилжүүлэхгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллах.

3. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Шилэн дансанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг шилэн дансны мэдээллийг 869.4 сая төгрөгийн мэдээлэх ёстойгоос 747.8 сая төгрөгийн мэдээлж нийтдээ 121.6 сая төгрөгийг шилэн дансанд дутуу мэдээлсэн байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 2,437.3 сая төгрөгийг мөнгөн гүйлгээг шилэн дансанд мэдээлсэн боловч тус цэсэд орлогыг мэдээлэх ёстойгоос цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээг байршуулж алдаатай мэдээлсэн байна. Шилэн дансны хэрэгжилт 94.8 хувьтай байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд мэдээлээгүй таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний 121.6 сая төгрөгийн, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 2,437.3 сая төгрөгийг мөнгөн гүйлгээг нөхөж байршуулан зөрчлийг арилгах;

4. Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилттэй холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Тамгын газар нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлээгүй / бичиг хэргийн зардал 42.4 сая төгрөг, Тээвэр шатахууны зардал 142.3 сая төгрөг г.м/ байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44.1-т Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.”, 46.1-т “Захиалагч худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүнг тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан төсөл, арга хэмжээ бүрээр харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр тайлагнана.” гэсэн заалттай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2 Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлж ажиллах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хувь хүний орлогын албан татвар суутгаагүй урамшуулал олгосон	1	19,579.4	1	19,579.4								
1.Балансын шагнал болон ЗДТГ-ын зарим Төрийн албан хаагчид олгох урамшууллын мөнгийн хэмжээг хэтрүүлэн олгосон, 2.Томилолтын мөнгийг тооцож олгохдоо, хоолны хөнгөлөлтийг давхардуулан олгосон байна.	1	40,019.9			1	40,019.9						
Хөрөнгийг орлогод авч данс бүртгэлд тусгаагүй	1	35,980.0					1	35,980.0				
Өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй	1	7,573.1					1	7,573.1				
Засаг даргын нөөц хөрөнгөөр зарцуулсан хөрөнгийг тус журмын 6.1-ийг баримтлаагүй	1	69,826.1			1	69,826.1						
Дүн	5	172,978.5	1	19,579.4	2	109,846.0	2	43,553.1				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны хуулийг хангаж ажиллаагүй.	1	2,578,495.4					1	2,578,495.4
Дүн	1	2,578,495.4					1	2,578,495.4
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлээгүй байна.	1	0					1	0
Дүн								
Нийт дүн	2	2,578,495.4					2	2,578,495.4